

## ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

/2018.03.23-2018.04.24/

### УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 9 дүгээр хурлаар Төрийн дээд “Алтан гадас” одонгоор шагнуулах тухай, Сумын мал сүргийг халдварт өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд шаардагдах эм бэлдмэлийн захиалга батлах тухай, Сумын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн дэх нарийн бичгийн даргыг өөрчлөн батлах тухай гэсэн 3 асуудлыг хэлэлцэж баталлаа.

Сумын “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-ний дагуу “Газар хөдлөлтийн тухай ойлголт, дуут дохиогоор ажиллах заавар” сэдэвт сургалтыг 2018 оны 03 сарын 28-нд иргэдийн дунд зохион байгуулж 21 иргэн хамрагдлаа.



Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолын дагуу 2018 оны 03 сарын 29-ны өдрийн 16:00 цагт “Газар хөдлөлтийн дуут дохио”-гоор ажиллах дадлага сургуулилтанд сумын 13 аж ахуйн нэгж байгууллага, 1, 2-р багийн нийт 847 иргэн, 56 авто машин хамрагдсан. Мөн Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолын дагуу нүүлгэн шилжүүлэх ажилд 56 автомашины бэлэн байдлыг хангаж ажилласан.



Сумын Засаг даргын 2018 оны 04 сарын 23-ны өдрийн А/49 тоот захирамжаар “Цэрэг татлага” зохион байгуулах комисс томилогдож 2018 оны 04 сарын 24-ны өдөр зохион байгуулагдаж байна.

### **ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ САНХҮҮ**

2018 оны 04-р сарын 23-ны өдрийн байдлаар орон нутгийн төсөвт байгууллагуудын санхүүжилт болон зардлын гүйцэтгэл өссөн дүнгээр дараах байдалтай байна.

№	Байгууллагын нэр	Санхүүжилт /мянган.төг/	Зардлын гүйцэтгэл /мянган.төг/
1.	ИТХ	14409000	13151000
2.	ЗДТГ	111311800	108272625

Төвлөрсөн төсөвт байгууллагуудын зардлын гүйцэтгэл дараах байдалтай байна.

№	Байгууллагын нэр	Санхүүжилт /төгрөгөөр/	Зардлын гүйцэтгэл /төгрөгөөр/
1.	Эрүүл мэндийн төв	121176800	106886047
2.	Соёлын төв	21735300	21279423
3.	3-р сургууль	257036300	250964838
4.	3-р цэцэрлэг	142550200	129163905

Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 04-р сарын 23-ны байдлаар 14 469 600 төгрөг бөгөөд гүйцэтгэл 10 975 000 төгрөг буюу 76 хувийн биелэлттэй байна.

## ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны Зөвлөл, Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газар хамтран Говьсүмбэр аймгийн төрийн албан хаагчдын ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх, хууль эрх зүйн мэдлэг мэдээлэл олгож, чадавхижуулах зорилгоор 2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулсан “Төрийн албан хаагчдын нэгдсэн сургалт”-нд сумын төрийн захиргааны 20, төсвийн байгууллагын 3 төлөөлөл хамрагдлаа.



Сумын эрүүл мэндийн төв, Соёлын төв, 3 дугаар сургуулийн дарга, захирал, эрхлэгч нарын 1-р улиралд гаргасан А, Б нийт 35 тушаалд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж зөвлөмжийг хүргүүлсэн.


### **БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ**

#### **3-Р СУРГУУЛЬ :**


3-р сургуулийн багш нар УИХ-ын гишүүн Г.Мөнхцэцэгийн санаачлагаар зохион байгуулж байгаа “Их соёл-Эх үндэс” зөвлөгөөнд хамрагдсан бөгөөд УИХ-ын гишүүн Г.Мөнхцэцэгийн тусламжаар БСШУСЯ-наас дотуур байрны тоног төхөөрөмж авах батламж гардан авлаа.

Аймгийн төрөлжсөн олимпиадад давхардсан тоогоор 92 сурагч оролцсоноос 29 сурагч медальт байранд орсон нь өмнөх жилийн амжилтаас 8 сурагчаар ахисан амжилт гаргасан байна. Мөн 18 багш олимпиадад орсноос 10 багш медальт байранд шалгарсан нь өмнөх жилийн амжилтаас 4 багшаар ахисан үзүүлэлттэй байна

Багш, сурагчдын сүүлийн 7 жилийн амжилтыг графикаар харуулбал:



Ахлах , дунд ангийн 3 дугаар улирлын дүнг эхний хоёр улирал болон өмнөх хичээлийн жилийн 3 дугаар улирлын дүнтэй харьцуулбал: Өмнөх хичээлийн жилийн III улирлын дүнгээс стандарт хангалт 0,8%-иар, АВ-гийн эзлэх хувь 0,9%- иар тус тус ахисан үзүүлэлттэй байна.



Говьсүмбэр аймгийн Засаг даргын нэрэмжит “Яргуй-2018” хүүхдийн урлагийн наадамд нийт 69 сурагч оролцсоноос 47 сурагч медаль хүртсэн.



Монголын Сурагчдын Холбооны дэргэдэх Лидер Сурагч Академиас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Оюуны давалгаа” уран илтгэлийн тэмцээнд 12

дугаар ангийн 2 сурагч оролцсоноос 12а ангийн сурагч Энхбаяр II байр эзэлж улсын аварга шалгаруулах илтгэлийн тэмцээнд оролцох эрх авсан.



### 3-Р ЦЭЦЭРЛЭГ

3-р цэцэрлэг нь Говьсүмбэр аймгийн Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын туслах багшийн мэргэжлийн уралдааныг “Хөдөлгөөнт тоглоом” сэдвээр 2018 оны 3-р сарын 23-нд сумандаа зохион байгууллаа. Тус уралдаанд нийт 7 цэцэрлэгийн туслах багш нар өрсөлдөж 2-р байранд 3-р цэцэрлэгийн туслах багш Л.Энхсүрэн шалгарлаа.



Говьсүмбэр аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан Болд багшийн нэрэмжит гимнастикийн 25 дахь удаагийн тэмцээнд 3-р цэцэрлэгийн Бэлтгэл бүлгийн хүүхдүүд амжилттай оролцож Тэргүүн байр эзлэн Алтан медаль, шилжин явах цом, өргөмжлөл хүртлээ.





### ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

- Эмнэлэгт хэвтсэн- 26 хүн үүнээс хүүхэд- 11 дотор- 15
- Амбулаторийн үзлэг – 231 хүн
- Урьдчилан сэргийлэх- 56 хүн
- Дуудлага-83

Албан байгууллага аж ахуйн нэгжүүдийг идэвхитэй дасгал хөдөлгөөнөөр хичээллүүлэх, дасгал хөдөлгөөнөөр эрүүлжих, орчин нөхцлийг бүрдүүлэх, эрүүл аж төрөх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх зорилгоор “Хийн дасгал”-ын тэмцээнийг зохион байгуулж 6 ААН, Албан байгууллага оролцсоноос эхний 3 байрыг шалгаруулан шагнаж урамшууллаа.



“Сүрьеэ өвчинтэй тэмцэх дэлхийн өдөр”-ийн хүрээнд “Сүрьеэ өвчинөөс урьдчилан сэргийлэх” талаар сумын албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд сургалт зохион байгуулж 150 өрхөд гарын авлага тарааж ажиллалаа. Сургалтанд 128 иргэн хамрагдлаа.



Монгол улсын Засгийн газрын тогтоолоор “Элэг бүтэн Монгол-2” үндэсний хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагаа улс орон даяар нэгэн зэрэг 2018 оны 04 сарын 04-ний өдөр эхлэсэн бөгөөд тус өдрөөр төрийн болон төрийн бус байгууллага, албан байгууллага, аж ахуйн нэгж, 15-40 насны иргэдийг 2018 оны 04 сарын 04-ний өдөр Эрүүл мэндийн төвийн байранд нээлтийн үйл ажиллагаанд оролцуулж 100 иргэнийг шинжилгээнд хамруулан гарын авлага тараан ажиллалаа.



## ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖ

Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 2018 оны 03 сарын 26, 04-р сарын 16-ны өдрүүдэд зохион байгуулж 8 иргэний өргөдлийг шийдвэрлэн мөнгөн тэтгэмжид хамрууллаа. Асаргааны мөнгөн тэтгэмжид 4 иргэний сунгалт хийж, 4 иргэнийг шинээр



хамруулсан. Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид 4 иргэний сунгалт хийж, 4 иргэнийг шинээр хамрууллаа. Шинээр нээлгэсэн хувийн хэрэг болон хөнгөлөлт, тусламж, сунгалт хийлгэсэн иргэдийн материалыг баталгаажуулан 25 иргэнд 1824670 төгрөгийг олгосон.

Сумын хөдөлмөрийн аюулгүй байдлын эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлөөс гаргасан “Аюулгүй амьдралын төлөө” сарын аяны төлөвлөгөний дагуу 2018 оны 04-р сарын 11-ний өдөр албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн ХАБЭА хариуцсан ажилтнуудыг “Шивээ-Овоо” ХК-ийн үйл ажиллагаатай танилцуулан туршлага судлуулах ажлыг зохион байгууллаа.



2018 оны 04-р сарын 20-ны өдрийн байдлаар 4 иргэнийг 3-р сургуульд ажилд зуучилсан.

### УЛСЫН БҮРТГЭЛ

Иргэний бүртгэлийн үйлчилгээг 2018 оны 3 дугаар сарын 22-ноос 2018 оны 4 дүгээр сарын 22-ны байдлаар 105 иргэнд үзүүлсэн ба үүнээс шинэчилсэн бүртгэлд 10 иргэнийг бүртгэж баримтыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасагт хүлээлгэн өгч экспорт хийлгээд байна.

2018 оны 04-р сард газраа анх удаа өмчилж авч байгаа 5 иргэний материалыг хүлээн авч газар өмчлөлийн гэрчилгээг олгоод байна. Эхний 4 сарын өссөн дүнгээр 17 иргэн газар өмчлөлийн гэрчилгээг аваад байна.

### ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ 2018 ОНЫ 04 САРЫН МЭДЭЭ

	м/д	Бүгд	Үүнээс:						
			Хот			Хөдөө			
			Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	



Төрсөн хүүхэд	1	30				30	12	18
Төрсөн эх	2	30				30		30
Бүртгүүлсэн гэр бүл	3	12				12	12	12
Нас баралт	4	6				6	3	3
Цуцалсан гэр бүл	5	3				3	3	3
Үрчлэгдсэн хүүхэд	6	1				1	1	-
Аймаг, нийслэлээс шилжин ирсэн	7	51				51	22	29
Аймаг, нийслэл рүү шилжин явсан	8	27				27	17	10

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС ОРСОН ОРЛОГО**

Д/д	Үйлчилгээний нэр төрөл	2018 оны 04-р сар					Бүгд	Тайлбар
		Үйлчилгээний хураамж 30020002210 тоот дансанд		Бүгд	Тэмдэгтийн хураамж 300300123138 тоот дансанд			
		Нэг бүрийн үнэ	Тоо		Нэг бүрийн үнэ	Тоо		
1	Эцэг тогтоосны бүртгэл	2500	4	10000				
2	Гэрлэлтийн гэрчилгээний үнэ	2500	3	7500				
	Овог нэр өөрчлөлтийн гэрчилгээ	2500	2	5000				
	Үрчлэлтийн гэрчилгээ	2500	1	2500				
	Төрсний гэрчилгээ дахин олгосон	5000	3	15000				
3	Иргэний үнэмлэхний үнэ	15000	21	315000	3300	21	69300	
	Өөр аймаг шилжин явсан	2500	2	5000	1000	2	2000	
4	Аймаг доторх шилжилт хөдөлгөөн	1500	7	10500	1000	7	7000	
<b>ДҮН</b>		<b>370500</b>			<b>78300</b>			
<b>НИЙТ ДҮН</b>		<b>448800</b>						

## **МАЛ ЭМНЭЛЭГ ҮРЖЛИЙН ТАСАГ**

2018 оны 04-р сарын 19-ний өдрийн байдлаар 256 үнээ тугаллаж 256 тугал, 4152 хонь хургалж 4352 хурга, 3303 ямаа ишиглэж 3518 ишиг гарснаас 25 хурга, 46 ишиг хорогдож нийт 8186 төл бойжиж байна.

Том малын зүй бус хорогдол нь 04-р сарын 19-ний өдрийн байдлаар тэмээ-1, адуу-41, үхэр-27, хонь-138, ямаа-234 нийт 441 мал хорогдсон байна.

Орчны бохирдлоос шалтгаалсан аливаа халдварт өвчин гарах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд байгаа үхсэн мал, амьтны сэг зэмийг устгах ажлыг Сумын Засаг даргын 2018 оны А/30 тоот Захирамжаар “Мал эмнэлгийн ариун цэвэр халдваргүйтгэл, сэг зэм устгалын ажил”-ыг зохион байгуулах ажлын хэсэг томилогдон 10 хоног ажиллаж 7 төрлийн 961 мал, амьтны сэг зэмийг устгаж ариутгал, халдваргүйтгэл хийж булах ажлыг зохион байгууллаа.



Сумын малчин өрхүүдээр 2018 оны 04 дүгээр сарын 18, 19-ний өдрүүдэд ажиллаж мал төллөлт, төл бойжилт, малын хорогдлын мэдээ, ноолуурын гарцын судалгаа, малчдын хаваржилтын байдалтай танилцлаа. Сумын ноолуурын гарцын дундаж 485 гр байна.

Хуц, ухна ялгалтын ажил зохион байгуулагдаж 2018 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар 49 хуц, 26 ухна ялгаад байна.

## **ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН**

2019 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх бараа, ажил үйлчилгээний саналыг 1, 2-р багийн нийт 866 иргэдээс авч 3-н ангиллаар эрэмбэлэн ажиллаж байна.

2018 оны орон нутгийн хөгжлийн сангийн 50 сая төгрөгийн хөрөнгөөр Эрүүл мэндийн төвд эхо томографик 4D аппарат худалдан авах барааны нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулж 2018 оны 02 дугаар сарын 28-ний өдөр тендерийг цахимаар зарлаж нээлтээ хийсэн бөгөөд тендерт 2 компани тендерээ ирүүлсэн боловч шаардлагад нийцсэн тендер шалгараагүй болно.

Сумын Засаг даргын 2018 оны А/37 захирамжаар байгуулагдсан “Соёлын төвийн дулаан, цэвэр усны шугамыг сольж шинэчлэх” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсэг хуралдаж “Чандмань” иргэдийн бүлэгтэй 4985700 төгрөгөөр тус ажлыг гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан урьдчилгаа 70 хувийн санхүүжилтийг олгосон.

Сумын Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/26 тоот захирамжаар “Нохой, муур устгах ажлыг зохион байгуулах комисс” томилогдон 2018 оны 03 дугаар сарын 21-ний өдөр сумын 2-р багийн иргэнтэй гэрээ байгуулан ажиллаж 04-р сарын 09-ний өдрийн байдлаар 23 нохой устгаад байна.

Сумын Засаг даргын 2018 оны А/34 тоот захирамжаар байгуулагдсан “Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар, үйлчилгээ хийх” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсэг хуралдаж “Эрчим” иргэдийн бүлэгтэй гэрээ байгуулахаар шийдвэрлэсэн.

Сумын Засаг даргын 2018 оны А/40 тоот захирамжаар байгуулагдсан “3 дугаар цэцэрлэгийг тохижуулах/гэр зөөлөн эдлэл” худалдан авах барааг нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсэг хуралдаж 3 аж ахуйн нэгжид үнийн санал авахаар ажлын даалгаварыг хүргүүлсэн.

Сумын Засаг даргын 2018 оны А/35 тоот захирамжаар байгуулагдсан “Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжуудад бут, сөөг тарих, усалгаа, арчилгаа, хамгаалалт хийх, цэцэрлэгт хүрээлэнг цэцэгжүүлэх” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсэг хуралдаж 2 аж ахуйн нэгж байгууллага, 1 иргэнд үнийн санал авахаар ажлын даалгаварыг хүргүүлсэн.



Сумын Засаг дарга хүсэлт гаргасны дагуу аймгийн Засаг даргын 2018 оны А/125 тоот захирамжаар “Бага оврын цэвэрлэх байгууламжийн зураг төсвийн ажлын даалгавар боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж ажлын даалгаварыг боловсруулах шатандаа байна. Мөн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын ажлын хэсэг, үнэлгээний хороо байгуулагдаж ажлын даалгавар, тендерийн баримт бичиг боловсруулах ажил хийгдэж байна.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ДАХОХААХМэргэжилтэн

С.Банзрагч